



**ДОРНОГОВЬ АЙМАГ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР**

103 дугаар байр, Дэнжийн гудамж, 2 дугаар баг,
Сайншанд сум, Дорноговь аймаг, 44105

Утас: 77370751

Цахим шуудан: dornogovi@sport.gov.mn

2025. 01. 20 № 21
танай 2024. 12. 16 -ны № 03/1744 -т

Г Тайлан хүргүүлэх тухай Г

Г АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН Г
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАТ-ЭРДЭНЭ
ТАНАА

Тус газраас аймгийн Засаг даргын 2022 оны А/675 дугаар захирамжийн дагуу дараах тайланг гаргаж хүргүүлэв. Үүнд:

1. Байгууллагын үйл ажиллагааны тайлан,
2. Биеийн тамир, спортын газрын 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт,
3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт,
4. Архив, албан хэрэг хөтлөлтийн тайлан,
5. Өргөдөл гомдолын шийдвэрлэлт, хариутай бичиг, үүрэг даалгаврын биелэлтийн тайлан,
6. Байгууллагын ил тод байдлын тайлан,
7. Хэрэглэгчийн үнэлгээний тайлан,
8. Ногоон байгууламжийн чиглэлээр хийсэн ажлын тайлан,
9. Хог хаягдлын менежментийн талаар хийгдсэн ажил, арга хэмжээний тайлан,
10. Цахим шилжилтийн талаар хийгдсэн ажил арга хэмжээний тайлан
Хүлээн авч танилцана уу.

Хавсралт. //...хуудастай.



440200007




ДОРНОГОВЬ АЙМГИЙН БИЕЙИН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

2024 он



УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР



Биесийн тамир, спортын газар нь аймгийн Засаг дарын 2023 оны А/73 дугаар захиралжад баталсан 70 орон тооноос 2024 оны жилийн эцсийн байдлаар 57 албан хаагчтайгаар ажиллаж, хүний неөцийн нөхөн хангалтyg бурдүүлэхэд анхааран ажиллаж байна. Сул орон тооны талаарх мэдээллийг газрын www.dorhogobi.sport.gov.mn цахим хуудас, байгууллагын мэдээллийн самбарт байршуулж, аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт хүргүүлэн "Бизнес хотөч-89,1" FM, орон нутгийн DSB төлөвзээр нэвтрүүлж, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын пэйж хуудас, орон нутгийн бүх сайтууд, багийн ажлын албаны цахим хуудсуудаар мэдээллийг иргэдэд хүргэж, мөн газрын мэргэжилтнээс ажлын байрны шалгуур, шаардлага хангасан иргэдийн талаарх мэдээллийг авч ажилласан. Мөн сумдын биесийн тамирын арга зүйч, дасгалжуулагчдын сул орон тоог бурдүүлэхэд хамтран ажиллах талаар сумдын Соёл, спортын төвийн эрхлэгч наарт, хүргүүлж ажилласнаар шалгуур шаардлага хангасан төрийн захиргааны 1, төрийн үйлчилгээний 14 албан хаагчийг албан тушаалд томилон ажилтуулж байна.

Тус газар 2024 онд 127 өргөдөл, гомдол хүлээн авснаас ажилд орох 13, өөрийн санаачилгаар чөлөөлөгдхөх 10, захиргааны чөлөө хүссэн 74, бусад асуудлаар 30 өргөдөл бүртгэгдэж 97 буюу 75,2 хувь нь ажилд орох томилуулах, чөлөөлөгдхөх, захиргааны чөлөө хүссэн асуудлаар, 30 буюу 23,2 хувь нь бусад асуудлаар хандсан байна. Нийт өргөдөл гомдлыг цаасаар ирүүлсэн бөгөөд иргэдээс ирүүлсэн өргөдөл 20 буюу 17,7 хувь, албан хаагч, ажилтнуудаас ирүүлсэн өргөдөл 107 буюу 84,2 хувийг эзэлж 100 хувь хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан.



ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР



Тус газрын цалингийн зардалд улсын төсвэес 870,6 сая төгрөг батлагдсанаас 2024 оны гүйцэтгээр 675,5 сая төгрөг, орон нутгийн төсвэес 640,9 сая төгрөг батлагдан байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж 8 сум болон Сайншанд сумын Зүүнбаян багийн спортын ордны ажилчдын цалинд 637,9 сая төгрөгийг тус тус зарцуулан ажилласан.

Спортын ордны тогтмол зардалд орон нутгаас 563,5 сая төгрөг батлуулан 563,1 сая төгрөгийг гэрэл, цахилгаан, тулш халаалт, цэвэр, бохир усны зардалд төсвийг үр ашигтай зарцуулан өр төлбөр үүсгээгүй ажиллаж, байгууллагын шилэн дансанд болон мэдээллийн самбарт ил тод байдлыг ханган мэдээлтүүдийг тогтмол байршуулан ажиллаж байна.

Улсын төсвэес 2024 онд спортын хетэлбэр, арга хэмжээг санхүүжүүлэхэд 1,115,349.7 мянган төгрөг батладсан ба 2024 оны 12 сарын 31-ний байдааар гүйцэтгээр 883,506.9 мянган төгрөгийг зарцуулан батлагдсан төсвийг 231,842.8 мянган төгрөг буюу 20.8 хувиар хэмнэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан.

2024 онд 73 албан хаагч, ажилтнуудад ажлын үр дүнгээр 25-40 хувийн мөнгөн урамшуулал, 73 ажилтанд ур чадварын нэмэгдэл, 73 ажилтанд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, мастерийн нэмэгдэл 1 ажилтанд, ажил хавсрэн гүйцэтгэсэн нэмэгдэл 40 хувийг 1 ажилтанд, хоол унааны зардал 73 албан хаагч, ажилтнуудад олгож ажилтнуудын нийгмийн баталгааг ханган ажиллаж байна. Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэн "Цагаан сар"-ын баяр, Ахмадын баярыг тохиолдуулан байгууллагын 12 ахмад настанд нэг удаагийн буцалтгүй туслаамж олгож, хүндэтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулсан.



НИЙТИЙН БИЕЙИН ТАМИРЫН ЧИГЛЭЛЭЭР



Эрүүл мэндийн газартай хамтран идэвхтэй хөдөлгөөнийг иргэдэд уриалан "Хийн дасгалын аймгийн аварга шалгаруулах тэмцээн"-ийг 2006 оноос жил бүр тасралтгүй зохион байгуулж нийт 240 багийн 2700 тамирчин, "Сурагчдын дундах Flash mob" тэмцээнийг 2022 оноос жил бүр зохион байгуулж нийт 72 багийн 1080 сурагчид оролцсон. Мөн "Сайншандын цом"-ын аварга шалгаруулах тэмцээнд 209 "Khamar Monastery-2023" засмал замын ба уулын дугуйн уралдаанд Өмнөговь, Сэлэнгэ, Ховд, Улаанбаатар хотын 250, аймгийн ёсвériйн дугуйн спортын аварга шалгаруулах тэмцээнд 70 тамирчид биеийн дархлааг дэмжиж хөдөлгөөний хомсдолоос үүсэх ёвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ЭМГ, БШУГ, БТСГ хамтран "Эрүүл ирээдүй – Бидний мөрөөдөл" уриатай "FLASH MOB" тэмцээнийг аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн Ахлах, Дунд бүлгийн сурагчдын дунд зохион байгууллаа.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулагдсан “Цаг гаргай” аяны арга хэмжээ 11 дүгээр сарын 30-наас 12 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл хуваарийн дагуу аймаг, сум, төрийн болон төрийн бус байгууллага, спортын холбоо, клубүүдтэй хамтран фитнес, гүйлт, алхалт, нийтийн бүжиг, шугаман бүжгийн төрлөөр 06:30-09:00 цагийн хооронд зохион байгуулж ажилласан. Тус арга хэмжээнд Айраг, Дэлгэрэх, Зүүнбаян сумын нийт 2300 хүн хамрагдсан.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг намар болон хаврын уриралд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын нийт 6149 (эрэгтэй-2673, эмэгтэй-3476) иргэд хамруулж А үнэлгээтэй 19,4%, В үнэлгээтэй 25,2%, С үнэлгээтэй 29,9%, D үнэлгээтэй 21,2%, F үнэлгээтэй 4,3%-тай дүгнэгдсэн. Мөн иргэдийн бие бялдрын ерөнхий хөгжил, хөдөлгөөний идэвхийг тодорхойлох суурь судалгааг улс даяар 18-64 насны 7000 иргэнээс асуулга, антропометрийн хэмжилт, бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилоор авах ажлыг зохион байгуулахтай холбогдуулан 250 иргэнээс судалгааны мэдээллийг



СПОРТЫН УРАЛДААН, ТЭМЦЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР



Олон улсын болон аймаг, бус нутгийн хэмжээнд "Сайншандын цом"-ын ёсвériйн дугуйчдын аварга шалгаруулах тэмцээн, "Жюу жицу"-ийн "Дорноговь орөн" Дэлхийн чансааны 800 оноо олгох бүсийн зэрэглэлийн Олон улсын тэмцээн, "Хөгжлийн лиг-2024", "Шинэ эхлэл" хүүхдийн лиг, "Gobi guys" сагсан бөмбөгийн лигийн тэмцээн, Шагайн харвааны аймгийн аварга шалгаруулах, чөлөөт, жудо бөх, даам, шатрын ёсвériйн аймгийн аварга шалгаруулах, Боксын аймгийн аварга шалгаруулах зэрэг 100 удаагийн тэмцээнд (аймгийн төвд 39, сумдад 61) 5836 тамирчдыг оролцуулан, спортын үйл ажиллагаанд 33123 иргэнийг хамруулсан.

Зохион байгуулсан тэмцээний үеэр зохион байгуулагчид, арга зүйч, дасгалжуулагч нар тамирчид болон иргэдийг эмх цэгцтэй, сахилга баттай тэмцээнд оролцож, бие биенийгээ хүндлэн, хүлээцтэй хамтран ажиллахыг уриалан, заавар, зөвлөгөө, чиглэл өгч ажиллалаа.



ИХ СПОРТЫН ТӨРӨЛ, ШИГШЭЭ БАГИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, ГАДААД, ДОТООДЫН ТЭМЦЭЭН УРАЛДААНД ОРОЛЦОХ ТАМИРЧДАД ҮЗҮҮЛСЭН ДЭМЖЛЭГ



Монгол Улсын начин А.Хатансайханы нэрэмжит улс, аймгийн цолтой 128 бөхийн барилдаанд 10,0 сая, Олон улсын хэмжээний мастер М.Нандинтушигийн нэрэмжит холимог насны боксчдын аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 2.4 сая, аймгийн аварга шалгаруулах бильярдын тэмцээнд 2,5 сая, сар шинийн бөхийн барилдаанд 7,5 сая, боксын шигшээ багийн тамирчин залуучуудын Азийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль хүртэж, Олон улс, аймаг, бусийн тэмцээнд оролцсон баг, тамирчдад аймгийн Засаг даргаас 4 сая, БНХАУ-ын ӨМӨЗОрны Манжуур хотод зохион байгуулагдсан Олон улсын “Хийн дасгал”-ын тэмцээнд оролцсон аймгийн Хийн дасгалын холбооны тамирчдад 2,453,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Аймгийн орон нутгийн төсвөөс 23,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж томоохон 5 үйл ажиллагааг зохион байгуулсан.

БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ САН

Facebook Нүүр худас Нүүр худас Утас: 7797-0751 E-mail: dornogovi@sport.gov.mn

ДОРНОГОВЬ АЙМГИН
БИЕЙИН ТАМИР СПОРТЫН
ГАЗАР

НҮҮР БИДНИЙ ТУХАЙ - ХУУЛЬ ЭРХ, ЗҮЙ - ИЛ ТӨД БАЙДАЛ - МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ - ХАМТЫН АЖИЛЛАГАА - ХОЛБОО БАРИХ -

Дорноговь Аймгийн Биеийн Тамир Спортын Газар

dornogovi@sport.gov.mn

Facebook Нүүр худас Нүүр худас Харьяа байгуулалт засгийн гарынх тимнэгжийн клик

Manage Page Дорноговь Биеийн Тамир Спортын Газар

Professional dashboard Insights Ad Center Create ads Settings

БИЕЙИН ТАМИР СПОРТЫН ГАЗАР

Edit cover photo

Дорноговь Биеийн Тамир Спортын Газар 5.4K likes • 6.3K followers

Posts About Mentions Reviews Followers Photos More

Add bio Page: Sports Event Not yet rated (1 Review)

Promote Type here to search

Edit details

Дорноговь Биеийн Тамир Спортын Газар

ДОРНОГОВЬ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Биелэлт	Үнэлгээ
Зорилт-1: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ				
1	Арга хэмжээ 1.1 “Эрүүл Монгол Хүн” өглөөний дасгалыг тогтмол явуулна.	Хамрагдагчдын тоо	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөн, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд шугаман бүжиг, хийн дасгал, ажлын байрны дасгал, өвөл цагийн түйлтийн тэмцээнүүдийг зохион байгуулах. Мөн “Бүх нийтийн гүйлт”-ийн арга хэмжээнд нийт 300 хүн, Хутагтын нутаг-Шамбалын орноор 100км-ын Явган алхалт зохион байгуулж, нийт Улаанбаатар хот, 3 аймгийн 122 алхагч, оролцсон. Тус газар нь аймгийн хэмжээнд 24 холбоод, клубүүдтэй хамтран ажиллах гэрээний дагуу спортын 12 секц дугуйланд өсвөрийн болон насанд хүрэгчдийг хичээллүүлж, 43 төрийн байгууллага болон хувийн ААН-тэй заалаар үйлчлэх гэрээ байгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх дасгал хөдөлгөөнийг хийлгэж давхардсан тоогоор 10099 шугаман бүжгийн сонирхон хичээллэгсэд давхардсан тоогоор 5676, спортын үйл ажиллагаанд 43484 иргэнийг хамруулсан. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх ажил, арга хэмжээнд нийт 59259 иргэд хамрагдсан.</p>	100
2	Арга хэмжээ 1.2 Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж спорт заалаар үйлчилж нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.	Гэрээ байгуулсан аж ахуй нэгж, албан байгууллагын тоо	<p>Спортын холбоодтой хамтран Дорноговь олон Жюу жицууний олон улсын нээлттэй тэмцээн, Сагсан бөмбөгийн Үндэсний супер лигийн бүсийн финалын тогтолц, Говийн бүсийн шагайн харваан тэмцээн, Зүүн бүсийн шатарчдын аварга шалгаруулах тэмцээн, Чөлөөт бөх, жudo, шатар, даам, дугуй, бокс, шагайн харваа, нийтийн бүжиг, үндэсний бөх, волейболын өсвөрийн болон насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүд, Сагсан бөмбөгийн Говь гаяс лиг, Волейболын хөгжлийн лиг, Шинэ эхлэл хүүхдийн лигийн тэмцээнүүд тус тус зохион байгууллаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөн, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Бүх нийтийн гүйлт</p>	100

			арга хэмжээ 2024 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулагдлаа. Нийт 300 хүн оролцсон. Хутагтын нутаг-Шамбалын орноор 2024 100км-ын Явган алхалт зохион байгуулагдсан. Нийт Улаанбаатар хот, 3 аймгийн 122 алхагч оролцсон. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 24 холбоод, клубүүдтэй хамтран ажиллах гэрээний дагуу спортын 12 секц дугуйланд 38841 ёсверийн болон насандаа хүрэгчдийг хичээллүүлж, 43 төрийн байгууллага болон хувийн ААН-тэй заалаар үйлчлэх гэрээ байгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх дасгал хөдөлгөөнийг хийлгэж давхардсан тоогоор 10099, шугаман бүжгийн сонирхон хичээллэгсэд давхардсан тоогоор 5676 иргэд, спортын үйл ажиллагаанд 43484 иргэнийг хамруулсан. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх ажил, арга хэмжээнд нийт 59259 иргэнд хамрагдсан.	
Зорилт-2: Аймгийн засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ				
3	Арга хэмжээ 2.1 "Унадаг дугуй" арга хэмжээг хэрэгжүүлэх	Унадаг дугуйгаар хичээллэгсдийн тоо нэмэгдэнэ.	<p>Аймгийн дугуйн спортын, аялалын "Хулан" клубээс санаачлан унадаг дугуйг нийтийн хэрэглээ болгохоор аймгийн хэмжээнд судалгаа хийж, судалгааны дүнд үндэслэн ойрын дугуйн аялал, зугаалгыг жил бүр явуулж хэвшсэн. Аймгийн хэмжээнд нийт 233 хүн унадаг дугуйг хэрэглээний болон спортын зориулалтаар тогтмол хэрэглэж дугуйн спортоор хичээллэгсдийн тоо 20-30 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан "Сайншандын цом"-ын ёсверийн дугуйчдын аварга шалгаруулах тэмцээн 70, Улын дугуйн ёсверийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 48, дугуйн спортын улсын аварга шалгаруулах тэмцээн 11, ДАРХАН-88" уулын дугуйн төвийн бүсийн IV наадмын багийн буухиа гарсаа 15, Говийн бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг тус тус оролцсон. 2024 онд хичээллэгсдийн тоо 70, сонирхогчдын тоо 233 болж өссөн үзүүлэлттэй байна.</p>	100
4	Арга хэмжээ 2.2 Үндэсний спортын төрлийг хөгжүүлэхэд спортын холбоо, клубүүдтэй хамтарч ажиллах	Хамтран ажилласан холбоо, клубүүдийн тоо	<p>Үндэсний спортын төрлүүдийг сурталчлах таниулах, өвлөн уламжлуулах зорилгоор аймгийн Шагайн холбоотой хамтран "Говийн бүсийн сар шинийн харваас 2024", харваачдын аймгийн аварга шалгаруулах тэмцээн, аймгийн аварга шалгаруулах үндэсний шагайн харвааны тэмцээн, ахмадын аймгийн аварга шалгаруулах шагайн харвааны Үндэсний бөхийн улсын аварга</p>	100

			<p>шалгаруулах, Өмнөговь аймгийн Даланзадгад хотын улсын аварга шалгаруулах тэмцээнийг тус тус зохион байгуулж ажиллалаа.</p> <p>Биеийн тамир, спортын газрын Спорт цогцолборт шагай харвааны өрөө байрлаж, ахмад харваачид, залуучууд, шагай сонирхогчид бэлтгэл сургуулилт хийх орчинг бүрдүүлж, үндэсний бөхийн барилдаанд бөхийн эд хэрэглэлээр ханган ажилласан. Сумдуудад иргэдийн дунд өв соёлоо түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Адуучин”, “Сурын харваа”, “Буухиа тэмцээн”, “Шагайн харваа”, “Халз харваа”, зэрэг тэмцээнүүдийг иргэдийн дунд зохион байгуулж, 318 гаруй иргэд оролцсон.</p> <p>Соёл спортын ордонтой харьяа сумдуудад /8 сум, Сайншанд сумын 5-р баг/ үндэсний бөхийн дугуйланд 756, Шагайн харвааны дугуйланд 2127, үндэсний сурын дугуйланд 1290 хүүхэд тогтмол хичээллэж байна. Нийт давхардсан тоогоор 4173 байна.</p>	
5	Арга хэмжээ 2.3 Спортын ордон байгуулахад ордонд ажиллах нийтийн биеийн тамирын арга зүйч, мэргэжлийн багш, дасгалжуулагч нарыг бэлтгэх ажилд хамтран ажиллана. /Алтанширээ сум/	Арга зүйч, дасгалжуулагчдын тоо	<p>Тус аймгийн Алтанширээ суманд Спортын ордон барих үйл ажиллагаа 50 хувийн гүйцэтгэлтэй, одоогоор ашиглалтанд ороогүй болно.</p>	70
6	Арга хэмжээ 2.4 Улс, бүсийн тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулна.	Зохион байгуулсан тэмцээний тоо	<p>Тус аймагт зохион байгуулагдсан “Дорноговь опен” Дэлхийн чансааны 800 оноо олгох бүсийн зэрэглэлийн Олон улсын тэмцээнд дөрвөн улсын 30-аад клубын 600 орчим тамирчин оролцсон. 2024 онд Олон улсын чанартай 2 тэмцээн, Улсын бүсийн чанартай 2 тэмцээн зохион байгуулагдсан.</p>	100
7	Арга хэмжээ 2.5 Өсвөрийн шигшээ багийн тоо, медалийн чанарыг ахиулна.	Шигшээ багийн төрлийн тоо, медалийн үзүүлэлт	<p>Биеийн тамир, спортын газар 2024 онд 19 холбоод, клубүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулан спортын 12 төрлөөр (сагсан бөмбөг, гар бөмбөг, хөл бөмбөг, жоу жицу зэрэг) сургалт, дугуйлан хичээллүүлж, аймгийн өсвөр үеийн 12 шигшээ багт 630 гаруй тамирчид тогтмол хичээллэж байна.</p> <p>Тайлант онд аймгийн Биеийн тамир, спортын газар спортын 19 холбоо, клубтэй хамтран ажиллах гэрээ байгуулж сагсан бөмбөг, волейбол, хөл бөмбөг, жоу жицу зэрэг спортын 12 төрлөөр сургалт, дугуйлан хичээллүүлж өсвөр үеийн 12 шигшээ багийг бүрдүүлэн 630 гаруй тамирчин тогтмол хамрагдаж байна.</p>	100

			<p>Монгол Улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль 105, мөнгөн медаль 90, хүрэл медаль 87-г хүртсэнээр Олон улс, бүс, орон нутгийн чанартай 10 гаруй тэмцээнд аймгийн баг тамирчид оролцож амжилтын чанараа өмнө оныхоос 100%-иар ахиуллаа.</p> <p>Боксын шигшээ багийн тамирчин залуучуудын Азийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль хүртлээ. Олон улс, аймаг, бүсийн тэмцээнд оролцсон баг, тамирчдад аймгийн Засаг даргаас 4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Тамирчдын бэлтгэлийг ханган наадам, тэмцээнд оролцуулах, амжилтыг нэмэгдүүлэх зорилгоор "Хөгжлийн лиг-2024", "Шинэ эхлэл" хүүхдийн лиг, "Gobi guys" Сагсан бөмбөгийн лигийн тэмцээнийг зохион байгуулж 2028 гаруй тамирчид өрсөлдөж, 9056 гаруй хүн үзсэн.</p> <p>ЕБС-ын сурагчдын дунд "Шинэ эхлэл" хүүхдийн лигийн тэмцээнийг зохион байгуулж, 65 багийн 600 гаруй өсвөрийн тамирчид оролцсон. 27,3 сая төгрөгийг зарцуулсан.</p>	
Зорилт-3: Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан арга хэмжээ				
8	Арга хэмжээ 3.1 Хүн амын хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор спортын холбоо, клубүүдтэй хамтарч ажиллах	Хамтын ажиллагаатай спортын холбоо, клубүүд	<p>Тус газар нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөн, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Бүх нийтийн түйлт арга хэмжээ 2024 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулагдлаа. Нийт 300 хүн оролцсон. Хутагтын нутаг-Шамбалын орноор 2024 100км-ын Явган алхалт зохион байгуулагдсан. Нийт Улаанбаатар хот, 3 аймгийн 122 алхагч оролцсон. Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг 03 дугаар сарын 18-наас аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын 18-64 нас, ЕБСургууль, цэцэрлэгийн 3-17 насны хүүхдүүдээс сорил, асуумж авч давхардсан тоогоор 6149 иргэдийг хамруулан сорилыг авч ажилласан. Аймгийн хэмжээнд 24 холбоод, клубүүдтэй хамтран ажиллах гэрээний дагуу спортын 12 секц дугуйланд өсвөрийн болон насанд хүрэгчдийг хичээллүүлж, 43 төрийн байгууллага болон хувийн ААН-тэй заалаар үйлчлэх гэрээ байгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх дасгал хөдөлгөөнийг хийлгэж давхардсан тоогоор 10099 шугаман</p>	100

			бүжгийн сонирхон хичээллэгсэд давхардсан тоогоор 5676, спортын үйл ажиллагаанд 43484 иргэнийг хамруулсан. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх ажил, арга хэмжээнд нийт 52259 иргэнд хамрагдсан. Аймгийн шугаман бүжгийн багштай хамтран Ахмадын сувилалд 7 хоног бурийн Баасан гарагт очиж дасгал хөдөлгөөн зааж сурган хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлж байна.	
9	Арга хэмжээ 3.2 Аймгийн хэмжээний лигийн тэмцээнүүдэд /Сагсан бөмбөг, Воллейбол гэх мэт/ зохион байгуулалтад хамтран оролцох	Хамтран ажилласан лигийн хэмжээний тэмцээн уралдааны тоо	Спортын холбоодтой хамтран Сагсан бөмбөгийн Үндэсний супер лигийн бүсийн финалын тогтолт, Сагсан бөмбөгийн Говь гаяс лиг, Волейболын хөгжлийн лиг, Шинэ эхлэл хүүхдийн лигийн тэмцээнүүд тус тус зохион байгууллаа. 2024-2025 оны Говь гаяс сагсан бөмбөг, Хөгжлийн лиг, "Ирээдүй" хүүхдийн лиг, "Шинэ эхлэл" хүүхдийн лигийн тэмцээнийг зохион байгуулж ажилласан.	100
10	Арга хэмжээ 3.3 Хөдөлгөөн эрүүл мэнд дэд хөтөлбөрийг цаашид хөгжүүлэх, сурталчлах	"Хөдөлгөөн эрүүл мэнд" дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Биеийн тамир, спортын газар болон шугаман бүжгийн холбоотой хамтран хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлж, 7 хоног бурийн Баасан гарагт "Төвшинсайхан амралт"-ын газарт очиж дасгал хөдөлгөөн хийж хэвшсэн.	100
11	Арга хэмжээ 3.4 Мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын чадвар, амжилтыг дээшлүүлэх	Баг тамирчдын амжилт, медалийн чанар	Тус аймгийн тамирчид тив, дэлхий, улсын чанартай тэмцээн уралдаанаас 115 алт, 90 мөнгө, 93 хүрэл, хүртсэн байна. Мэргэжлийн спортыг дэмжин аймаг орон нутагтаа Олон Улсын 2, аймгийн аварга шалгаруулах 10, залуус, хүүхэд багачуудын дунд сагсан бөмбөг, волейболын төрлөөр 3 удаагийн лигийн тэмцээнийг зохион байгуулж 2500 гаруй тамирчидыг оролцуулж, 11000 гаруй иргэн хамрагдсан.	100
12	Арга хэмжээ 3.5 Үндэсний спортыг дэмжих	Хичээллэгчдийн тоо, амжилт /Бөх, сур, шагайн харваа...гэх мэт/	Үндэсний спортын төрлүүдийг сурталчлах таниулах, өвлөн уламжлуулах зорилгоор аймгийн Шагайн холбоотой хамтран энэ оны 02 дугаар сард "Говийн бүсийн сар шинийн харваа 2024", 03 сард цолгүй харваачдын аймгийн аварга шалгаруулах тэмцээн, ахмадын аймгийн аварга шалгаруулах үндэсний шагайн харвааны тэмцээн, ахмадын аймгийн аварга шалгаруулах шагайн харвааны тэмцээнийг тус тус хамтран зохион байгуулсан. Үндэсний спортыг сурталчлан хөгжүүлэх ажлын хүрээнд дээрх тэмцээнийг зохион байгуулж, байгууллагын цахим хуудаст мэдээллийг тухай бүр байршуулан ажилласнаар иргэдийг үндэсний спортоор хичээллэх, монгол бахархлыг бий болгон ажилласан. Биеийн тамир, спортын газрын Спорт цогцолборт шагай харвааны	100

			<p>өрөө байрлаж, ахмад харваачид, залуучууд, шагай сонирхогчид бэлтгэл сургуулilt хийх орчинг бүрдүүлж, үндэсний бөхийн барилдаанд бөхийн эд хэрэглэлээр ханган ажилласан. Сумдуудад иргэдийн дунд өв соёлоо түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Адуучин”, “Сурын харваа”, “Буухиа тэмцээн”, “Шагайн харваа” зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулж хэвшсэн. Соёл спортын ордонтой харьяа сумдуудад /8 сум, Сайншанд сумын 5-р баг/ үндэсний бөхийн дугуйланд 112, Шагайн харвааны дугуйланд 108, үндэсний сурын дугуйланд 31 хүүхэд тогтмол хичээллэж байна. Нийт хичээллэгч хүүхдийн тоо 251 байна.</p> <p>Үндэсний спорт болон бусад спортын төрлөөр улсын чанартай болон тив дэлхийн чанартай тэмцээн уралдаанд медальт байр эзэлсэн тамирчдад тус оны эцэст Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу жил бүр мөнгөн урамшуулалт олгож хэвшсэн. 2024 оны Үндэсний бөхийн ёсверийн улсын аварга шалгаруулах тэмцээнд Мандах сумын ёсверийн бөх Г.Цэрэнбаяр түрүүлсэн. 2024 оны үндэсний шагайн харваан улсын аварга шалгаруулах тэмцээнд Б.Баттулга ахлагчтай “Номт даншиг” баг гутгаар байр эзэлсэн. Хүрээ цам 2024 Даншиг наадмын шагайн харвааны эхний 3 байрт Дорнговь аймгийн баг тамирчид шалгарсан.</p>	
13	Арга хэмжээ 3.6 “Дорнговь Бага олимп” спортын арга хэмжээг зохион байгуулах	Спортын төрөл, зохион байгуулсан тэмцээний тоо	“Дорнговь бага олимп” спортын наадам тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон.	70
Зорилт-4:Биеийн тамир, спортын тухай хуулийн хүрээнд:				
14	Арга хэмжээ 4.1 Аймгийн Засаг даргын дэргэдэх ёсверийн шигшээ багийг спортын 8-аас дээш төрлөөр зохион байгуулан сургалт дасгалжуулалт явуулах	Спортын төрлийн тоо, хичээллэгчдийн тоо	<p>Тайлант онд аймгийн Биеийн тамир, спортын газар спортын 19 холбоо, клубтэй хамтран ажиллах гэрээ байгуулж сагсан бөмбөг, волейбол, хөл бөмбөг, жюү жицу зэрэг спортын 12 төрлөөр сургалт, дугуйлан хичээллүүлж ёсвэр үеийн 12 шигшээ багийг бүрдүүлэн 630 гаруй тамирчин тогтмол хамрагдаж байна.</p> <p>Монгол Улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль 105, мөнгөн медаль 90, хүрэл медаль 87-г хүртсэнээр Олон улс, бүс, орон нутгийн чанартай 10 гаруй тэмцээнд аймгийн баг тамирчид оролцож амжилтын чанараа өмнө оныхоос 100%-иар ахиуллаа.</p> <p>Боксын шигшээ багийн тамирчин залуучуудын Азийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль хүртлээ. Олон улс, аймаг, бүсийн тэмцээнд оролцсон баг, тамирчдад аймгийн Засаг даргаас 4</p>	100

			<p>сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Тамирчдын бэлтгэлийг ханган наадам, тэмцээнд оролцуулах, амжилтыг нэмэгдүүлэх зорилгоор "Хөгжлийн лиг-2024", "Шинэ эхлэл" хүүхдийн лиг, "Gobi guys" Сагсан бөмбөгийн лигийн тэмцээнийг зохион байгуулж 2028 гаруй тамирчид өрсөлдөж, 9056 гаруй хүн үзсэн.</p> <p>ЕБС-ын сурагчдын дунд "Шинэ эхлэл" хүүхдийн лигийн тэмцээнийг зохион байгуулж, 65 багийн 600 гаруй ёсвөрийн тамирчид оролцсон. 27,3 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>2020-2023 онд Монгол Улсын спортын мастер боксын дасгалжуулагч Г.Баасанг 3 жилийн хугацаатай урьж хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан.</p> <p>Дорнговь аймгийн Эмэгтэйчүүдийн холбооны урилгаар Монгол улсын Волейболын спортын мастер Г.Хандсүрэн, Д.Эрдэнэбулган нар 06 дугаар сарын 20-ны өдөр ирж волейболын олон улсын дүрэм, волейболын спортын техникийн талаар практик сургалт, 3 цагийн турш үзүүлэн тоглолтыг амжилттай зохион байгууллаа. Сургалтад волейбол сонирхогч 80 гаруй эмэгтэйчүүд, 10 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд Аймгийн Сагсан бөмбөгийн холбоотой хамтран Сагсан бөмбөгийн олон улсын шүүгчийг урин авчирч сагсан бөмбөгийн шүүгч бэлтгэх сургалтыг зохион байгууллаа. Нийт 24 хүн хамрагдсан.</p>	
15	Арга хэмжээ 4.2 Бүс, олон улсын чанартай тэмцээн уралдаанд бэлтгэн оролцох	Оролцогчдын тоо, амжилт	<p>Дорнговь аймгийн Засаг даргын 2021 оны А/171 дүгээр захирамжаар "Өсвөр үе, залуучуудын шигшээ баг"-ийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь үргэлжлүүлэн дэмжих арга хэмжээг батлан, тив, дэлхий, улсын хэмжээнд аймаг, орон нутгийнхаа нэрийг өндөрт өргөн, медаль хүртсэн тамирчид, бэлтгэл сургуулилтыг ханган оролцуулсан дасгалжуулагчдыг урамшуулан, тэдний амжилтыг ахиулах зорилгоор 2022 онд амжилт гаргасан 90 тамирчин, 10 дасгалжуулагчийг, 2023 онд амжилт гаргасан 233 тамирчин 14 дасгалжуулагчийг тус тус урамшуулсан. Тайлант онд тус болзол шалгуур хангасан тамирчдыг оны эцэст урамшуулахаар төлөвлөж байна. 10 дугаар сарын байдлаар Дорнговь аймгийн тамирчид тив, дэлхий, улсын чанартай тэмцээн уралдаанаас 115 алт, 90 мөнгө, 93 хүрэл медаль хүртсэн байна.</p>	100
Зорилт-5: Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах.				

16	Арга хэмжээ 5.1 Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг тогтмол тайлагнах	Заасан хугацаанд холбогдох дээд шатны байгууллагад тайлан явуулах	Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийн мэдээг аймгийн Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн албан бичгийн дагуу тус газрын 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 06 дугаартай албан бичгээр хавсралт хүснэгтийн дагуу гаргаж хүргүүлсэн.	100
17	Арга хэмжээ 5.2 Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан баталж, төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган тайлагнах	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд төлөвлөн байгууллагын даргаар батлуулсан. Мөн тайланг хагас бүтэн жилээр гарган ажилласан.	100
18	Арга хэмжээ 5.3 Биеийн тамир, спортын тайлан мэдээ, мэдээллийг хууль тогтоомжид заасан журмын дагуу холбогдох байгууллагад гаргаж өгөх	Цаг үеийн болон улирал, хагас, бүтэн жилийн тайлан, шаардлагатай судалгаа мэдээллийг гаргах	Цаг үеийн болон улирал, хагас, бүтэн жилийн тайлан мэдээ, шаардлагатай судалгаа мэдээллийг хууль тогтоомжид заасан журмын дагуу холбогдох байгууллагад цаг хугацаанд нь гаргаж ажилласан.	100
19	Арга хэмжээ 5.4 Бичиг хэрэг, архивын ажилтанг сургалтанд хамруулж ур чадварыг нэмэгдүүлнэ.	Ур чадвар дээшилнэ. Хамрагдсан сургалтын too	Тус газрын архив, бичиг хэрэг архивын ажилтан 2024 оны 02 дугаар сарын Б/14 тушаалаар өөрийн санаачилгаар ажлаас чөлөөлөгдж, ажлын байр сул байгаа болно.	70
20	Арга хэмжээ 5.5 ХАСУМ, ХАСХОМ-ыг хугацаанд нь холбогдох дээд шатны байгууллагад тайлагнах.	Хуулийн хугацаа буюу 2 сарын 15 өдрийн дотор холбогдох албан хаагчид АЗДТГ-ын хуулийн хэлтэст журмын дагуу үнэн бодитой гаргаж өгөх.	Хуулийн хугацаа буюу 2 сарын 15-ны өдрийн дотор Төрийн захиргааны албан хаагчид болох Байгууллагын дарга, Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийн ахлах мэргэжилтэн нар АЗДТГ-ын хуулийн хэлтэст журмын дагуу үнэн бодитой гаргаж өгөх.	100
21	Арга хэмжээ 5.6 Холбогдох дээд шатны байгууллагаас ирүүлсэн үүрэг, чиглэлийг цаг тухай бүрт биелүүлж ажиллах.	Харьяа хэлтэс, тасагт шилжүүлэн үүрэг чиглэлийг	Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Биеийн тамир, спортын улсын хороо, Аймгийн Засаг даргаас ирүүлсэн үүрэг чиглэлийг тухай бүр биелүүлж ажилласан.	100

		биелүүлэн ажиллах.		
22	Арга хэмжээ 5.7 Биеийн тамир, спортын ажилтнуудын Нийгмийн баталгааг хангаж, сайжруулах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	Батлагдсан албан хаагчдын Нийгмийн баталгаа, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	"Биеийн тамир, спортын газрын төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг батлан хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган 2024 оны 11 сарын байдлаар давхардсан тоогоор 46 албан хаагч, ажилтнуудад ажлын үр дүнгээр 20-50 хувийн мөнгөн урамшуулал, 172 ажилтанд ур чадварын нэмэгдэл, хоол унааны зардал, орон нутгийн нэмэгдэл нийт албан хаагч, ажилтнуудад олгосон. Өндөр насын тэтгэвэр тогтоолгосон 1 ахмад ажилтан, ава, эзж, төрсөн ах нь нас барсан 3 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгон ажилласан. Хаврын тэргүүн сарын шинийн нэгэн "Цагаан сар", Ахмадын баярыг тохиолдуулан байгууллагын 14 ахмад настан, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан тус газарт ажилладаг эмэгтэй албан хаагч, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрүүдэд ажилтнуудын хүүхдүүдэд тусгай хөтөлбөрийн дагуу хүндэтгэл үзүүлж бэлэг дурсгалын зүйл гардуулах арга хэмжээг тус тус зохион байгуулсан. Ажилтнуудыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор 7 хоног бүрийн Лхагва гарагт спорт зааланд бие бялдарын бэлтгэлжилтэнд хамрагдаж, эрүүл аж төрөх, зөв хооллолтын талаар ажилтнуудад сургалтыг оруулж, багуудын хооронд спортын тэмцээн уралдааныг зохион байгуулж ажилласан. Мөн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулж өрөө тасалгаа, амралтын өрөөг тохижуулж, үйлчилгээний ажилтнуудыг 2 ээлжийн ажлын хувцасаар ханган ажилласан. Ажилтнуудын сайн дурын үндсэн дээр байгуулагдсан "Хамтын сан"-гаас давхардсан тоогоор 48 ажилтанд 2,350,000 төгрөгийн мөнгөн тусламж үзүүлж, гэр болон галлагаатай байшинд амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрс авахад тусламж үзүүлсэн.	100
23	Арга хэмжээ 5.8 Байгууллагын сургалтын хөтөлбөр батлаж, хэрэгжүүлэх	Байгууллагын ажилчид, албан хаагчдыг чадавхижуулах мэдлэгийг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр	Тус газраас 2024 онд зохион байгуулах 8 заалт бүхий ажлын төлөвлөгөө, сар бүр мэдвэл зохих хууль тогтоомж болон хөгжүүлэх чиглэлээрх сургалтын календарчилсан төлөвлөгөөг 24 заалтаар батлан, хэрэгжүүлэн ажиллаж байна. Сургалтын танхимд ухаалаг дэлгэц болон цахим сургалт зохион байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг байрлуулж мэдээлэл технологийн дэвшилтэт хэрэгслээр явуулж сумдын албан хаагчдыг zoom-эр сургалтанд хамрагдах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.	100

		батлагдсан байна.		
24	Арга хэмжээ 5.9 Байгууллагын дотоод хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулах	Байгууллагын дотоод хяналт шалгалтыг холбогдох журмын дагуу хагас, бүтэн жилээр зохион байгуулсан байна.	Монгол улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын дагуу Биеийн тамир спортын газрын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн дотоод хяналт шалгалтын журам батлан хэрэгжилтийн ханганд 2024 оны эхний хагас жилд газрынг даргын баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулж, сүүлийн хагас жилийн шалгалтыг явуулж дуусаагүй байгаа болно.	100
25	Арга хэмжээ 5.10 Улс болон олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах, их наадмын тэмцээнээс медаль хүртсэн баг тамирчид, багш дасгалжуулагчдад мөнгөн урамшуулалт олгох.	Журманд заасан шалгуурыг хангасан баг, тамирчдын тоо, амжилт	Дорноговь аймгийн Засаг даргын 2021 оны А/171 дүгээр захирамжаар "Өсвөр үе, залуучуудын шигшээ баг"-ийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь үргэлжлүүлэн дэмжих арга хэмжээг батлан, тив, дэлхий, улсын хэмжээнд аймаг, орон нутгийнхаа нэрийг өндөрт өргөн, медаль хүртсэн тамирчид, бэлтгэл сургуулилтыг ханганд оролцуулсан дасгалжуулагчдыг урамшуулан, тэдний амжилтыг ахиулах зорилгоор 2022 онд амжилт гаргасан 90 тамирчин, 10 дасгалжуулагчийг, 2023 онд амжилт гаргасан 233 тамирчин 14 дасгалжуулагчийг тус тус урамшуулсан. Тайлант онд тус болзول шалгуур хангасан тамирчдыг оны эцэст урамшуулахаар төлөвлөж байна. 10 дугаар сарын байдлаар Дорноговь аймгийн тамирчид тив, дэлхий, улсын чанартай тэмцээн уралдаанаас 115 алт, 90 мөнгө, 93 хүрэл медаль хүртсэн байна.	100
ЗУРГАА: Биеийн тамир, спортын улсын хорооны төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээ				
26	Арга хэмжээ 6.1 Иргэдийн спортын төрөлжсөн наадам зохион байгуулах	Наадам зохион байгуулагдсан байх	Иргэдийн спортын наадмыг 11 дүгээр сард сумдууд аймгийн төвд 2 үе шаттай зохион байгуулахаар бэлтгэл ажил хангаж байна.	100
27	Арга хэмжээ 6.2 Аймгийн иргэдийн дунд бүх нийтийн марафон зохион байгуулах	Марафон зохион байгуулагдсан байх	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Бүх нийтийн гүйлт арга хэмжээ 2024 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Нийт 300 хүн оролцсон.	100
28	Арга хэмжээ 6.3 Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал	Сорилд хамрагдсан иргэдийн бие	Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд нийт 6149 иргэд хамрагдсан. Сорилыг хувь хүний биеийн ачаалал даах чадвар болон биеийн дотоод бүтцийг тодорхойлох	100

биелүүлэх норм нормативыг насны ангиллаар тогтоож мөрдүүлэх, насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх хөтөлбөр хэрэгжүүлэх	бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт, /насны ангиллаар/ сорилд хамрагдсан А, В, С үнэлгээтэй хүний тоог сорилд хамрагдсан хүний тоонд харьцуулж 100- аар үржүүлэн хувиар тооцно.	чиглэлээр авч, гарсан үр дүнгээр хүн бүрд зөвлөгөө өгч ажилласан. Бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын үр дүнд 74%-тай дүгнэгдсэн. Түвшин тогтоох сорил бүрийн үр дүнг судалгаанд оролцогчдод танилцуулж тохирох зөвлөгөө өгч хамтран ажилласан.	
Нийт оноо: 2710 (28 ажил, арга хэмжээ)			
Дундаж хувь: 96,7%			
Үнэлгээ: 4,8			

БИЕЛЭЛТ ХЯНАСАН:
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫН АРГА ЗҮЙЧ



Г. БАТЛХАМ

Ч. ОТГОНЧУЛУУН